



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Тайлант онд хэрэгжиж дуусгахаар гэрээ байгуулсан 7 төсөл, арга хэмжээнээс 57.2 хувь буюу 4 нь бүрэн хэрэгжиж, улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.

АУДИТЫН НЭР: УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СЭА-2026/05-17-ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум	Дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх	
	Утас: 70363040	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
2026 он	Ахлах аудитор	Ц.Отгонбаяр
	Утас: 70363036	Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
2026 он	Ахлах аудитор	С.Баасансүрэн
	Утас: 70363047	Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com
	Аудитор Ж.Баясгалан	Цахим хаяг: Bayasgalanj@audit.gov.mn
	Аудитор Р.Отгонжаргал	Цахим хаяг: Otgonjargalr@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
Ерөнхий мэдээлэл	5
1 дүгээр бүлэг: “Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-тэй уялдуулаагүй, нийгмийн ач холбогдлыг үнэлж, эрэмбэлээгүй болон төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөж, эрх шилжүүлсэн байна.	7
1.1 “Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-тэй уялдуулж төлөвлөөгүй 3 төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймгийн Засаг даргад эрхийг нь шилжүүлсэн байна.	7
1.2 Тайлант онд шинээр хэрэгжүүлсэн 1 төсөл, арга хэмжээний угсралт, суурилуулалтын ажлын төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, баталгаажуулаагүй байна.	9
2 дугаар бүлэг: Тайлант онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаатай холбоотой захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр өргөдөл, гомдол гараагүй байна.	11
2.1 “Үнэлгээний хороо”-г захиалагч аймгийн Засаг даргын захирамжаар бус ХААГ-ын даргын тушаалаар байгуулсан байна.	11
2.2 Тайлант онд худалдан авах ажиллагаатай холбоотой захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр өргөдөл, гомдол ирээгүй байна.	14
3 дугаар бүлэг: Тайлант онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн нийт 12,940.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 3 төсөл, арга хэмжээ буюу 42.8 хувь нь дутуу хэрэгжсэн байна.	15
3.1 Тайлант онд ашиглалтад хүлээн авсан 1 төсөл, арга хэмжээний чанарын баталгааны 50.0 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулаагүй байна.	15
3.2 Тайлант онд 1,486.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй төсөл, арга хэмжээний явцад захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй байна.	18
3.3 Тайлант онд ашиглалтад хүлээн авсан нийт 4,932.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 3 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна.	19
Илрүүлсэн зөрчил	21
Дүгнэлт	21
Зөвлөмж	22
Ирүүлсэн санал, тайлбар	23
Төрийн аудитын газрын тайлбар	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОНХОБТХ	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Тендер шалгаруулалтын заавар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Дүрслэлийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Аймгийн Засаг даргаас 2025 оны УТХО-ын төлөвлөгөөнд тусгуулахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний жагсаалт	7
Дүрслэл 2	Төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч компаниудын өмнөөс гүйцэтгэлийн баталгаа гаргаж ирүүлсэн банк, даатгалын байгууллагын жагсаалт	13

Хүснэгтийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Тайлант онд чанарын баталгааны барьцааг чөлөөлсөн төсөл, арга хэмжээний жагсаалт	16

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: <ul style="list-style-type: none"> Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх, Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх, Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.
Аудитын хамарсан хүрээ:	Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн аймгийн ТЕЗ, ЗДТГ, ХААГ, ГХБХБГ, ОНӨГ зэрэг холбогдох бусад байгууллага болон төсөл, арга хэмжээний төлөвлөлт, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй:	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аймгийн ТЕЗ, ЗДТГ, ХААГ, ГХБХБГ, ОНӨГ-ын холбогдох албан тушаалтнуудтай

	<p>ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, худалдан авалт, санхүүжилттэй холбоотой баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитын шалгуур, үзүүлэлт:</p>	<p>Аудитад дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төсвийн тухай хууль, • Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт, • Төрийн хэмнэлтийн тухай хууль, • Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, • Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, • Барилгын тухай хууль, • Эрчим хүчний тухай хууль, • Авто замын тухай хууль, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, • “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, • УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, • Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, • Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, • Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, • Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, • Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”, • Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, • Сангийн сайдын 2023 оны А/261, 2025 оны А/106 дугаар тушаалаар тус тус баталсан “Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”, • Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт, • Барилга байгууламжийн үнэ бүрдэл, төсөв зохиох норм, дүрэм, стандарт,

	<ul style="list-style-type: none"> • Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актууд.
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:</p>	<p>Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх удирдаж, ахлах аудитор Ц.Отгонбаяр явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ж.Баясгалан, Р.Отгонжаргал нар 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс 4 дүгээр сарын 24-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.</p>
<p>Ерөнхий мэдээлэл:</p>	<p>Аймгийн Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, Сангийн сайдын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.2-т заасны дагуу УТХО-ын 2025 оны төлөвлөгөөнд тусгуулахаар нийт 660,075.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 67 төсөл, арга хэмжээний саналыг холбогдох баримт материалыг үндэслэн төлөвлөж, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем Publicinvestment.gov.mn-т оруулсан байна.</p> <p>Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 233 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Монгол Улсын 2025 оны төсвийн хөрөнгөөр аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-аар Сэлэнгэ аймагт 2025 онд шинээр хэрэгжих 11,183.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.</p> <p>“Үнэлгээний хороо” нь Сангийн сайдын 2023 оны А/258 дугаар тушаалаар баталсан “Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”, А/259 дүгээр тушаалаар баталсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу шинээр эхлэх 11,183.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулсан байна.</p> <p>Захиалагч аймгийн Засаг дарга нь өмнөх оноос шилжин хэрэгжих 5, шинээр эхлэх 2 зэрэг нийт 7 төсөл, арга хэмжээ (барилга байгууламж 6, тоног төхөөрөмж 1) -г тайлант онд хэрэгжүүлж дуусгахаар нийт 20,653.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.</p>

Бүлэг 1

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн үү?

“Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-тэй уялдуулаагүй, нийгмийн ач холбогдлыг үнэлж, эрэмбэлээгүй болон төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөж, эрх шилжүүлсэн байна.

1.1 Хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан, нэн тэргүүний хэрэгцээ шаардлагатай төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?

“Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-тэй уялдуулж төлөвлөөгүй 3 төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймгийн Засаг даргад эрхийг нь шилжүүлсэн байна.

1.1.1 Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Төсвийн төслийг боловсруулахдаа ... дараах шаардлага тавигдана: 27.1.8.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх”, 29¹1.2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх: 29¹1.2.5 ... хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх” гэж заасан байдаг.

1.1.2 Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Сэлэнгэ аймагт 4 яаманд харьяалагдах нийт 182,916.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталснаас аймгийн Засаг даргад нийт 11,183.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав.)

1.1.3 Тайлант онд УТХО-аар хэрэгжүүлэхээр баталж, аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн дээрх 3 төсөл, арга хэмжээ нь УИХ-ын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний дэд зорилтуудтай уялдуулаагүй байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав.)

1.1.4 Аймгийн Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2¹, Сангийн сайдын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.2²-т заасны дагуу УТХО-ын 2025 оны төлөвлөгөөнд тусгуулахаар нийт 660,075.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 67 төсөл, арга хэмжээний саналыг холбогдох баримт материалыг үндэслэн төлөвлөж, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем Publicinvestment.gov.mn-т оруулсан байна.

¹ Төсвийн ерөнхийлөн захирагч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах төсөл, арга хэмжээний саналаа хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.


² Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг Төсвийн тухай хуулийн 29/1-д заасан аргачлалын дагуу цахим системээр төлөвлөнө.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

1.1.5 Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системээр 2025 оны УТХО-ын төлөвлөгөөнд тусгуулах саналыг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр дараах графикаар харуулбал:

График №1. Аймгийн Засаг даргаас 2025 оны УТХО-ын төлөвлөгөөнд тусгуулахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөгөөр/



Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас 2025 онд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системээр хүргүүлсэн санал

1.1.6 Дээрх төсөл, арга хэмжээнээс 145,149.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээ нь 2025 оны УТХО-ын төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсанаас 4,040.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Дулааны станцын хамааралгүй схем 1 дүгээр хэлхээний ажил (Сэлэнгэ, Сүхбаатар сум 4 дүгээр баг)” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

1.2.4 Аймгийн Засаг даргын хүргүүлсэн нийт саналын 6.0 хувь нь УТХО-ын төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан бөгөөд эрх шилжүүлсэн дээрх 1 төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, эрэмбэлсэн байна.

1.2.5 Харин 2025 оны УТХО-ын төлөвлөгөөнд тусгагдаж, хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн 7,143.7 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцож, аргачлалын дагуу үнэлж,

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

эрэмбэлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1³ дэх заалттай нийцэхгүй байна.

1.1.6 Өөрөөр хэлбэл аймгийн Засаг даргаас санал хүргүүлээгүй, орон нутгийн хэрэгцээ шаардлага, нийгмийн ач холбогдлыг үнэлж, эрэмбэлээгүй дараах 2 төсөл, арга хэмжээг 2025 оны УТХО-аар хэрэгжүүлэхээр баталж, эрх шилжүүлсэн байна. Үүнд:



Зам тээврийн сайдын багцаас 5,643.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Орхон голын төмөр бетонон гүүрний дуусгал (Сэлэнгэ, Орхонтуул сум)



Сангийн сайдын багцаас 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Байгаль хамгаалал, цэнгээ усны ховордсон загасны үржүүлэг, аялал жуулчлалын төсөл (Сэлэнгэ)” зэрэг.

1.1.7 Дээрхээс дүгнэхэд 2025 оны УТХО-ын төлөвлөгөөнд тусгагдаж, эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлж, эрэмбэлэх ажил хийгдээгүй байгаа нь Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ыг бүхэлд нь зөрчсөн байна.

1.1.8 Дээрхээс үзэхэд аймгийн Засаг даргаас хүргүүлсэн саналын дөнгөж 6 хувьтай тэнцэх хэмжээний төсөл, арга хэмжээг УТХО-ын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байгаа нь аймаг, орон нутгийн нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, нийгэмд үзүүлэх эдийн засгийн үр дүнг бууруулж байна гэж дүгнэж байна.

1.2 Төсөвлөлтийн шаардлага хангасан, өртөг, санхүүжилт, хүрэх дүнг оновчтой тодорхойлсон төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?

Тайлант онд шинээр хэрэгжүүлсэн 1 төсөл, арга хэмжээний угсралт, суурилуулалтын ажлын төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, баталгаажуулаагүй байна.

1.2.1 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹2.1- 29¹2.6-д заасан тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан, зураг төсвөө сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажуулсан, урсгал зардлыг урьдчилан тооцсон, иргэд олон нийтээр хэлэлцүүлсэн төсөл, арга хэмжээг тусгахаар зохицуулагдсан байдаг.

1.2.2 Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 3 төсөл, арга хэмжээнээс нийт 9,683.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 барилга байгууламжийн зураг, төсвийг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹.2.2⁴, Барилгын тухай хуулийн 25 дугаар

³ Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна.

⁴ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх: 29¹.2.2.Барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх.

зүйлийн 25.2⁵-т заасны дагуу 2022, 2024 онд магадлалаар баталгаажуулсан байна.Үүнд:



5,643.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Орхон голын төмөр бетонон гүүрний дуусгал (Сэлэнгэ, Орхонтуул сум),



4,040.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Дулааны станцын хамааралгүй схем 1 дүгээр хэлхээний ажил (Сэлэнгэ, Сүхбаатар сум 4 дүгээр баг)”

1.2.3 Хэдийгээр уг 2 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг магадлалаар баталгаажуулсан ч зураг, төсөв боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, баталгаажуулаагүй байгаа нь Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 3.4⁶, 3.5⁷ дахь заалттай нийцэхгүй байна.

1.2.4 Дээрх 2 төсөл, арга хэмжээний хувьд газрын зөвшөөрөл, цахилгаан болон ариутгах татуурга, холбоо дохиоллын техникийн нөхцөлүүд шаардлагагүй бөгөөд 4,040.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Дулааны станцын хамааралгүй схем 1 дүгээр хэлхээний ажил (Сэлэнгэ, Сүхбаатар сум 4 дүгээр баг)” төсөл, арга хэмжээний дулаан хангамжийн техникийн зөвшөөрлийг авсан байна.

1.2.5 Захиалагч аймгийн Засаг дарга нь 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Байгаль хамгаалал, цэнгээ усны ховордсон загасны үржүүлэг, аялал жуулчлалын төсөл (Сэлэнгэ)” төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг төсөв батлагдсаны дараа буюу 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр боловсруулж, баталсан байна.

1.2.6 Дээрх төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтод зөөврийн болон цэвэрлэх байгууламж, ариутгах татуурга, гадна ус хангамж, агааржуулалт, нарны цахилгаан үүсгүүр, вакум коллектор, агуулахын болон цахилгааны зэрэг инженерийн шийдэл шаардлагатай угсралт, суурилуулалтын ажлын төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, баталгаажуулалгүйгээр нийт 242.6 сая төгрөгийг зарцуулахаар тооцож, төлөвлөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁸, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 1.4⁹ дэх заалтуудтай нийцэхгүй байна.

1.2.7 Харин орон нутгийн хэрэгцээ шаардлага, нийгмийн ач холбогдлын талаар олон нийтээр хэлэлцүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹.2.6¹⁰ дахь заалттай нийцэхгүй байна.

⁵ Магадлалыг дараах зураг төсөлд хийнэ: 25.2.5.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

⁶ Архитектур төлөвлөлтийн даалгаврыг аймаг, нийслэлийн ерөнхий архитектур батална.

⁷ Захиалагч барилга байгууламжийн байршлыг тогтоосон шийдвэр, батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэж зураг төслийн даалгавар боловсруулж батална.

⁸ Хөрөнгө оруулалтын төсөвт техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, ... төсөл, арга хэмжээг тусгана.

⁹ Зураг төслийг барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд Барилгын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу боловсруулна

¹⁰ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх: 29¹.2.6.олон нийтээр хэлэлцүүлсэн байх.

1.2.8 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5¹¹ дахь заалтыг мөрдөөгүй, санхүүжилтийг хэрэгжих хугацаанд нь тэнцүү хуваарилаагүйгээс дараах 2 төсөл, арга хэмжээний тухайн жилийн төсөв нийт 825.3 сая төгрөгөөр дутуу батлагдсан байна. Үүнд:



2024-2025 онд дамжин хэрэгжиж байгаа 5,000.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн агропарк (Сэлэнгэ)” төсөл, арга хэмжээний санхүүжилт 500.0 сая төгрөгөөр,



2025-2027 онд дамжин хэрэгжих 3,986.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Дулааны станцын хамааралгүй схем 1 дүгээр хэлхээний ажил (Сэлэнгэ, Сүхбаатар сум 4 дүгээр баг)” төсөл, арга хэмжээний санхүүжилт 325.3 сая төгрөгөөр дутуу.

1.2.9 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд нь тэнцүү хуваарилахгүй байгаа нь сонгон шалгаруулалт амжилтгүй болох, улмаар төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

1.2.10 УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлоогүй байна.

Бүлэг 2

Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьсан уу?

Тайлант онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаатай холбоотой захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр өргөдөл, гомдол гараагүй байна.

2.1 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу, хугацаанд нь зохион байгуулсан уу?

“Үнэлгээний хороо”-г захиалагч аймгийн Засаг даргын захирамжаар бус ХААГ-ын даргын тушаалаар байгуулсан байна.

2.1.1 Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.1¹²-т заасны дагуу холбогдох албан тушаалтанд шилжүүлэхээр зохицуулагдсан байдаг.

2.1.2 Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 233 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Монгол Улсын 2025 оны төсвийн хөрөнгөөр аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-аар

¹¹ ... төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана: 29.3.5 шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж дуусгах.

¹² Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна.

Сэлэнгэ аймагт 2025 онд шинээр хэрэгжих 11,183.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

2.1.3 Дээрхээс Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 25 дугаар тушаалаар 4,040.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Дулааны станцын хамааралгүй схем 1 дүгээр хэлхээний ажил (Сэлэнгэ, Сүхбаатар сум 4 дүгээр баг)” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна.

2.1.4 Харин Зам тээврийн болон Сангийн сайд нь журмаар тогтоосон хугацаа хоцроож буюу 2025 оны 03, 04 дүгээр сард дараах 2 төсөл, арга хэмжээний эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав.)
Үүнд:



Зам, тээврийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар 5,643.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Орхон голын төмөр бетонон гүүрний дуусгал (Сэлэнгэ, Орхонтуул сум),



Сангийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 72 дугаар тушаалаар 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Байгаль хамгаалал, цэнгээ усны ховордсон загасны үржүүлэг, аялал жуулчлалын төсөл (Сэлэнгэ)” .

Энэ нь төсөл, арга хэмжээг чанаргүй гүйцэтгэх, хугацаандаа ашиглалтад орохгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

2.1.5 Захиалагч буюу аймгийн Засаг дарга нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 44 дүгээр 44.1¹³-д заасны дагуу “Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан боловч уг төлөвлөгөөнд УТХО-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг тусгалгүйгээр ОНХО, ОНХС, Замын сан, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан байна.

2.1.6 Тайлант онд УТХО-аар шинээр хэрэгжих 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо”-г аймгийн ХААГ-ын даргын тушаалаар байгуулсан байна. Үүнд:



2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар “Дулааны станцын хамааралгүй схем 1 дүгээр хэлхээний ажил (Сэлэнгэ, Сүхбаатар сум 4 дүгээр баг) ”



2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/60 дугаар тушаалаар “Орхон голын төмөр бетонон гүүрний дуусгал (Сэлэнгэ, Орхонтуул сум)”



2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/67 дугаар тушаалаар “Байгаль хамгаалал, цэнгээ усны ховордсон загасны үржүүлэг, аялал жуулчлалын төсөл (Сэлэнгэ)”

¹³ Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1¹⁴, 48.2.2¹⁵ дахь заалтуудыг зөрчсөн байна.

2.1.7 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1¹⁶-д заасны дагуу дээрх 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо”-г тус бүр дарга, нарийн бичгийн дарга, гишүүн 3 зэрэг нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

2.1.8 “Үнэлгээний хороо” нь Сангийн сайдын 2023 оны А/258 дугаар тушаалаар баталсан “*Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг*”, А/259 дүгээр тушаалаар баталсан “*Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг*”-ийн дагуу шинээр эхлэх 11,183.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулсан байна. (*Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав.*)

2.1.9 Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1¹⁷-д заасны дагуу тайлант оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө зохион байгуулсан бөгөөд нийт 9,683.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаж, гүйцэтгэгчээр шалгарсан “Эрдэнэт суврага” ХК, “МЭЗ” ХХК-иудад гэрээ байгуулах эрх олгосон байна.

2.1.10 “Үнэлгээний хороо” нь 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “*Байгаль хамгаалал, цэнгээ усны ховордсон загасны үржүүлэг, аялал жуулчлалын төсөл (Сэлэнгэ)*” төсөл, арга хэмжээний инженерийн шийдэл шаардлагатай угсралт, суурилуулалтын ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн төсөвгүйгээр нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулан гүйцэтгэгчээр “Хидро-Инженеринг” ХХК-ийг сонгон шалгаруулж, 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр гэрээ байгуулах эрх олгосон байна.

2.1.11 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1¹⁸ дэх заалтын дагуу дээрх 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар сонгон шалгаруулснаар нийт 125.5 сая төгрөгийн тендерийн хэмнэлт үүсгэсэн байна. (*Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав.*)

2.1.12 “Үнэлгээний хороо” нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1¹⁹, 42.2²⁰-т заасны дагуу тендерийн баримт бичгийн ТШЗ-37.1-д гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх шаардлагыг тусгасан бөгөөд тайлант онд санхүүжих дүнгийн 3

¹⁴ Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад тусгагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч байна.

¹⁵ Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ: 48.2.2.үнэлгээний хороо байгуулах

¹⁶ Захиалагч энэ хуулийн 10.2-т зааснаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаас бусад тохиолдолд үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулна: 50.1.2 ... эсхүл энэ хуулийн 50.1.1-д зааснаас бусад тендер шалгаруулалтын үнэлгээний хороог таваас доошгүй

¹⁷ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохин байгуулахад дараах журмыг баримтална: 13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах

¹⁸ Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

¹⁹ Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.

²⁰ Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

хувьтай тэнцэх хэмжээний буюу нийт 242.2 сая төгрөгийн баталгааг ирүүлсэн байна. Үүнийг дараах графикаар харуулбал:

График №2. Төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч компаниудын өмнөөс гүйцэтгэлийн баталгаа гаргаж ирүүлсэн банк, даатгалын байгууллагууд

/сая төгрөгөөр/



2.2 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхийг хянаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн үү?

Тайлант онд худалдан авах ажиллагаатай холбоотой захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр өргөдөл, гомдол ирээгүй байна.

2.2.1 Аймгийн Засаг даргад эрх шилжсэн тайлант онд шинээр хэрэгжүүлэх нийт 11,183.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1²¹-д заасны дагуу цахимаар зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд мэдээлсэн байна.

2.2.1 Дээрх 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалттай холбоотой захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр өргөдөл, гомдол ирээгүй байна.

²¹ Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ

Бүлэг 3

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?

Тайлант онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн нийт 12,940.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 3 төсөл, арга хэмжээ буюу 42.8 хувь нь дутуу хэрэгжсэн байна.

3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь санхүүжүүлж, гүйцэтгүүлсэн үү?

Тайлант онд ашиглалтад хүлээн авсан 1 төсөл, арга хэмжээний чанарын баталгааны 50.0 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулаагүй байна.

3.1.1 Захиалагч аймгийн Засаг дарга нь өмнөх оноос шилжин хэрэгжих 5, шинээр эхлэх 2 зэрэг нийт 7 төсөл, арга хэмжээ (барилга байгууламж 6, тоног төхөөрөмж 1) - г тайлант онд хэрэгжүүлж дуусгахаар нийт 20,653.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.1.2 Үүнээс тайлант онд бүрэн хэрэгжсэн нийт 5,226.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 2 төсөл, арга хэмжээг улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авч “Гэрээ дүгнэх маяг”-аар баталгаажуулсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.1.3 Харин 1,486.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Байгаль хамгаалал, цэнгэг усны ховордсон загасны үржүүлэг, аялал жуулчлалын төсөл (Сэлэнгэ)” төсөл, арга хэмжээг аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн даргаар ахлуулсан “Ажлын хэсэг”-ийн актаар хүлээн авсан бол 1,000.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын хөгжлийн төвийн барилга худалдан авах (Сэлэнгэ, Сүхбаатар сум)” төсөл, арга хэмжээг аймгийн ОНӨГ-ын даргаар ахлуулсан “Ажлын хэсэг”-ийн актаар ашиглалтад хүлээн авсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.1.4 Өмнөх онд ажил гүйцэтгэх гэрээг оройтуулсан, барилгын материалын үнийн өсөлтөөс дахин магадлал хийлгэх, голын усны түвшин зун, намрын улиралд их байснаас гүүрний дам нурууны угсралтын ажил оройтсон зэрэг шалтгааны улмаас тайлант онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн нийт 12,940.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 3 төсөл, арга хэмжээ буюу 42.8 хувь нь дутуу хэрэгжсэн байна. Үүнд: (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)



Өмнөх оноос дамжин хэрэгжсэн 2,415.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга (Сэлэнгэ, Түшиг сум)”,



Өмнөх оноос дамжин хэрэгжсэн 4,939.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн агропарк (Сэлэнгэ)”,



Тайлант онд шинээр эхэлсэн 5,584.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Орхон голын төмөр бетонон гүүрний дуусгал (Сэлэнгэ, Орхонтуул сум)”.

3.1.5 Дээрх “Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн агропарк (Сэлэнгэ)” төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх хугацааг 2026 оны 12 дугаар сарын 02-ны, “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга (Сэлэнгэ, Түшиг сум)” төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх хугацааг 2026 оны 12 дугаар сарын 25-ны, “Орхон голын төмөр бетонон гүүрний дуусгал (Сэлэнгэ, Орхонтуул сум)” төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх хугацааг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.1.6 Тайлант онд өмнөх оноос шилжин хэрэгжих 8, шинээр эхлэх 1 зэрэг нийт 9 төсөл, арга хэмжээ (2025 онд 6, 2026 онд 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дуусахаар гэрээ байгуулсан) -ний явцын болон эцсийн санхүүжилтийг олгосон байна.

3.1.7 Төсөл, арга хэмжээний эхний болон явын санхүүжилтийг хяналт хэрэгжүүлсэн эрх бүхий албан тушаалтнуудын баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, ашиглагч байгууллагын тодорхойлолт, гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу 30.0-80.0 хувиар тооцож, гүйцэтгэгч компаниудад олгосон байна.

3.1.8 Аймгийн Засаг даргад санхүүжилтийн эрхийг шилжүүлээгүй тул 1,486.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Байгаль хамгаалал, цэнгээ усны ховордсон загасны үржүүлэг, аялал жуулчлалын төсөл (Сэлэнгэ)” төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Сангийн яамнаас гүйцэтгэгч “Хидро-Инженеринг” ХХК-д олгосон байна.

3.1.9 Харин 3,986.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Дулааны станцын хамааралгүй схем 1 дүгээр хэлхээний ажил (Сэлэнгэ, Сүхбаатар сум 4 дүгээр баг)” төсөл, арга хэмжээний эхний болон явцын санхүүжилтийг тайлант онд бус 2026 онд олгосон байна.

3.1.10 Улсын комиссын актаар хүлээн авсан 2, захиалагч аймгийн Засаг даргын томилсон ажлын хэсгийн комиссын актаар хүлээн авсан 2 зэрэг нийт 4 төсөл, арга хэмжээ (Өмнөх оноос шилжин хэрэгжсэн 3, тайлант онд шинээр эхэлсэн 1) -ний эцсийн санхүүжилтийг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.28²², 4.8.29²³-д заасны дагуу барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хяналтын хуудас, гүйцэтгэлийн төсвийг үндэслэн захиалагч “Гэрээ дүгнэх маягт”-аар баталгаажуулж олгосон байна.

3.1.11 Дээрх бүрэн хэрэгжсэн 4 төсөл, арга хэмжээний чанарын баталгааг гэрээний үнийн дүнгийн 5 хувиар тооцож, хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулахаар тусгасан бөгөөд нийт 5,226.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 2 төсөл, арга хэмжээний чанарын баталгаа 191.8 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулсан байна.

3.1.12 Харин 1,000.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын хөгжлийн төвийн барилга худалдан авах (Сэлэнгэ, Сүхбаатар

²² Захиалагч нь барилга байгууламж, их засварын ажил, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээ болон худалдан авах төсөл зэрэг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ тус бүрийн хяналтын хуудсыг энэ журмын хавсралтад заасан холбогдох маягтын дагуу бөглөж, баталгаажуулан ирүүлнэ.

²³ Төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлтэд гэрээг дүгнэсэн байх бөгөөд энэ журмын 16 дугаар хавсралтад заасан “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд эх хувиар хавсаргаж ирүүлнэ.


Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн


сум)” төсөл, арга хэмжээний чанарын баталгааны 50.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулаагүй байна.


Энэ нь 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн УТ2403901094 дугаар гэрээний “Тусгай нөхцөл”-ийн 4.15 дахь “... ажлыг бүрэн хүлээлгэн өгсний дараа гэрээний үнийн дүнгийн 95 хувийн санхүүжилтийг олгоно”, 4.16 дахь “Чанарын баталгаа 5 хувь байна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.


3.1.13 Өмнөх онуудад УТХО-аар хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний тухайн төсвийн жилийн үлдэгдэл санхүүжилтийг хөрөнгө оруулалтын барьцааны дансанд байршуулсан бөгөөд Сангийн яамны ТНБД-ын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 02/1136 дугаар албан бичгийн дагуу нийт 1,749.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.


3.1.14 Аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/630 дугаар захирамжаар гэрээний хугацаа болоогүй 2, тайлант онд ашиглалтад хүлээлгэн өгөөгүйгээс гэрээний хугацааг нь сунгасан 3 зэрэг нийт 5 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт болох нийт 210.1 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан байна. Үүнд:

 2026 онд хэрэгжүүлж дуусгахаар 10,004.6 сая төгрөгийн гэрээ байгуулсан “Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 10.3 км (Сэлэнгэ, Мандал сум)” төсөл, арга хэмжээний 36.0 сая төгрөг,

 2026 онд хэрэгжүүлж дуусгахаар 1,415.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан “Сургуулийн спорт заалны барилга (Сэлэнгэ, Сайхан сум, Номгон тосгон)” төсөл, арга хэмжээний 8.4 сая төгрөг,

 Хугацааг нь сунгасан 2,415.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга (Сэлэнгэ, Түшиг сум)” төсөл, арга хэмжээний 17.3 сая төгрөг,

 Хугацааг нь сунгасан 4,939.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан “Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн агропарк (Сэлэнгэ)” төсөл, арга хэмжээний 33.9 сая төгрөг,

 Хугацааг нь сунгасан 5,584.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан “Орхон голын төмөр бетонон гүүрний дуусгал (Сэлэнгэ, Орхонтуул сум)” төсөл, арга хэмжээний 114.5 сая төгрөг гэх зэрэг.

3.1.15 Захиалагч нь өмнөх онд улсын комиссын актаар хүлээн авсан, баталгаат хугацаанд чанарын гологдол гараагүй дараах 10 төсөл, арга хэмжээний барьцааг чөлөөлж гүйцэтгэгч компаниудад 300.9 сая төгрөгийг олгосон байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1. Тайлант онд чанарын баталгааны барьцааг чөлөөлсөн төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөгөөр/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компанийн нэр	Чанарын баталгаа чөлөөлсөн огноо	Мөнгөн дүн
1	Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөл	Девсофт ХХК	2025.02.26	25.4

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

2	Ерөнхий боловсролын сургуулиудын номын сангийн тоног төхөөрөмж нийлүүлэх	Технозон ХХК	2025.09.10	24.9
3	Алтанбулаг сумын Хярааны голын гүүр	Хайвэй интернэшнл групп ХХК	2025.09.10	14.8
4	Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуульд цахим анги байгуулах	Хос-Анар ХХК	2025.09.19	4.8
5	Мандал сумын Түнхэл тосгоны сургуульд цахим анги байгуулах	Хос-Анар ХХК	2025.09.19	4.8
6	Эрүүл мэндийн төвүүдэд тоног төхөөрөмж нийлүүлэх	Хос-Анар ХХК	2025.09.19	4.2
7	Алтанбулаг жишиг сумын ажил	Бажа мандал ХХК	2025.11.11	199.0
8	Жавхланта сумын ерөнхий боловсролын сургуульд цахим анги байгуулах	Хос-Анар ХХК	2025.11.24	4.9
9	Сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж нийлүүлэх	Гарааны шимт боловсрол ХХК	2025.12.31	14.9
10	Түшиг сумын цэцэрлэгийн их засварын ажил	Арвайн шагшаа ХХК	2025.12.31	3.2
Нийт дүн				300.9

3.2 Барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн үү?

Тайлант онд 1,486.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй төсөл, арга хэмжээний явцад захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй байна.

3.2.1 Тайлант онд хэрэгжүүлж дуусахаар гэрээ байгуулсан дээрх 7 төсөл, арга хэмжээ (барилга байгууламж 6, тоног төхөөрөмж 1) -ээс нийт 7,713.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 4 төсөл, арга хэмжээ нь батлагдсан зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гэрээний хугацаанд бүрэн хэрэгжсэнийг улсын болон аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон “Ажлын хэсэг”-ийн актаар ашиглалтад хүлээн авсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав)

3.2.2 Аймгийн ГХБХБГ нь барилга байгууламжийн өмнөх оноос шилжин ирсэн 8, тайлант онд шинээр эхэлсэн 2 зэрэг нийт 10 төсөл, арга хэмжээнд Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4²⁴, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.12²⁵-т заасны дагуу захиалагчийн хяналтыг гүйцэтгэсэн байна.

3.2.3 Тус газрын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий мэргэжилтнүүд нь Засгийн газрын 2019 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.9²⁶, Сангийн сайдын 2023 оны 287 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах,

²⁴ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.4.барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах.

²⁵ Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.

²⁶ Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.

тайлагнах журам”-ын 4.4.1.3²⁷-т заасны дагуу төсөл, арга хэмжээний явц бүрд захиалагчийн техник, технологийн хяналтын тэмдэглэл, явцын тайлан, дүгнэлтээр баталгаажуулж, илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.

3.2.4 Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5²⁸, Засгийн газрын 2019 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.1.4²⁹, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.2.3³⁰-т заасны дагуу төсөл, арга хэмжээний үе шат бүрд зураг, төсөв зохиогчийн техникийн хяналтыг гэрээний үндсэн дээр зураг, төсөв зохиогч компаниудаар гүйцэтгүүлж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулсан байна.

3.2.5 Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.19³¹-д заасны дагуу захиалагчийн болон зохиогчийн зүгээс барилгын ажлын үе шат бүрд хяналт тавьж, фото зураг болон ил, далд ажлын актаар баталгаажуулсан байна.

3.2.6 Тайлант онд бүрэн хэрэгжиж дууссан авто замын байгууламжийн 2 төсөл, арга хэмжээг “Захиалагчийн нэгдсэн дүгнэлт” болон “Зураг, төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлт”-ээр баталгаажуулж ашиглалтад хүлээн авах улсын комиссын гишүүнээр ажилласан байна.

3.2.7 Харин 1,486.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй “*Байгаль хамгаалал, цэнгэг усны ховордсон загасны үржүүлэг, аялал жуулчлалын төсөл (Сэлэнгэ)*” төсөл, арга хэмжээг гүйцэтгэх явцад захиалагчийн зүгээс хяналт тавиагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 2.8³² дахь заалтыг зөрчсөн байна.

3.3 Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг үнэлж бүртгэн зориулалтын дагуу ашиглаж байна уу?

Тайлант онд ашиглалтад хүлээн авсан нийт 4,932.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 3 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна.

3.3.1 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2³³, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.30³⁴-д

²⁷ Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийн санхүүжилтийн явц бүрд захиалагчийн техник, технологийн хяналтын тэмдэглэл, явцын тайлан, дүгнэлтийг тухай бүр гаргах

²⁸ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах.

²⁹ Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээ байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах.

³⁰ Зохиогчийн хяналтыг барилга байгууламжийн байршил, онцлогоос хамааруулан дараах 3 хэлбэрээр гүйцэтгэнэ.

3.2.3.барилгын ажлын үе шат бүрд хяналт тавих

³¹ Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:37.1.19.барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан ил, далд ажлын актыг баталгаажуулах

³² Захиалагч Барилгын тухай хуулийн 37.1.4-т заасан барилгын үе шатны ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилон ажиллуулна.

³³ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, ...

³⁴ Эцсийн буюу бүрэн санхүүжилтийг авахад тухайн төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж, баримт бичгийн иж бүрдэлд хавсаргах бөгөөд цахим системд баталгаажуулсан байна.

заасны дагуу хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгахаар зохицуулагдсан байдаг.

3.3.2 Аймгийн Орон нутгийн өмчийн газраас хөрөнгөд бүртгэх зөвшөөрөл олгосныг үндэслэн тайлант онд улсын комиссын актаар хүлээн авсан 2,780.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Хатуу хучилттай авто зам, 2.5 км (Сэлэнгэ, Баруунбүрэн сум)” төсөл, арга хэмжээг Баруунбүрэн сумын ЗДТГ нь бүртгэл, тайланд тусгасан байна.

3.3.3 Харин тайлан онд улсын комиссын актаар хүлээн авсан 1, захиалагчийн ажлын хэсгийн актаар хүлээн авсан 2 зэрэг нийт 4,932.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй дараах 3 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна. Үүнд:



1,000.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын хөгжлийн төвийн барилга худалдан авах (Сэлэнгэ, Сүхбаатар сум)”,



2,445.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Улсын чанартай авто замтай холбох хатуу хучилттай авто замын эхлэл (Сэлэнгэ, Хушаат сум)”,



1,486.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Байгаль хамгаалал, цэнгээг усны ховордсон загасны үржүүлэг, аялал жуулчлалын төсөл (Сэлэнгэ)” гэх зэрэг.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2³⁵, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.30³⁶ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.



3.3.4 Санхүүжилтийн эх үүсвэр, урсгал зардал зэргийг урьдчилан тооцож, төлөвлөөгүйгээс тайлант онд хүлээн авсан 1,000.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын хөгжлийн төвийн барилга худалдан авах (Сэлэнгэ, Сүхбаатар сум)” төсөл, арга хэмжээний дүнд бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж чадахгүй байна.

Зураг №1 Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын хөгжлийн төвийн гадна, дотор байдал

³⁵ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, ...

³⁶ Эцсийн буюу бүрэн санхүүжилтийг авахад тухайн төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж, баримт бичгийн иж бүрдэлд хавсаргах бөгөөд цахим системд баталгаажуулсан байна.



3.3.5 Тайлант онд хүлээн авсан 1,486.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Байгаль хамгаалал, цэнгээ усны ховордсон загасны үржүүлэг, аялал жуулчлалын төсөл (Сэлэнгэ)” төсөл, арга хэмжээний дүнд бий болсон Ерөө сумын нутаг дэвсгэрт байрлах загас үржүүлгийн төв нь зөвхөн дулааны улиралд ашиглагдах зориулалттай байна.

Зураг №2 Загас үржүүлгийн төвийн дотор, гадна байдал

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **4,982.6** сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

- Ажлын хэсгийн актаар хүлээн авсан 1 төсөл, арга хэмжээний чанарын баталгааны 50.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулаагүй байна.
- Тайлант онд улсын комиссын болон ажлын хэсгийн актаар ашиглалтад хүлээн авсан нийт 4,932.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй дараах 3 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- “Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-тэй уялдуулж төлөвлөөгүй 3 төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймгийн Засаг даргад эрхийг нь шилжүүлсэн байна.
- Тайлант онд шинээр хэрэгжүүлсэн 1 төсөл, арга хэмжээний угсралт, суурилуулалтын ажлын төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, баталгаажуулаагүй байна.
- “Үнэлгээний хороо”-г захиалагч аймгийн Засаг даргын захирамжаар бус ХААГ-ын даргын тушаалаар байгуулсан байна.
- Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалттай холбоотой захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр өргөдөл, гомдол гаргаагүй байна.
- Тайлант онд ашиглалтад хүлээн авсан 1 төсөл, арга хэмжээний чанарын баталгааны 50.0 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулаагүй байна.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

- Тайлант онд 1,486.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй төсөл, арга хэмжээний явцад захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй байна.
- Тайлант онд ашиглалтад хүлээн авсан нийт 4,932.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 3 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж-д:

- Тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтод инженерийн шийдэл шаардлагатай угсралт, суурилуулалтын ажлын төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, баталгаажуулсны үндсэн дээр иж бүрэн тусгах.
- Засаг даргын захирамжаар “Үнэлгээний хороо”-г байгуулж, худалдан авах ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх.
- Барилга, тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээг хүлээн авах “Ажлын хэсэг”-т мэргэжлийн албан хаагчдыг томилон ажиллуулах замаар үр нөлөө бүхий захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР



Б.БАТМӨНХ

Ц.ОТГОНБАЯР

С.БААСАНСҮРЭН

Ж.БАЯСГАЛАН

Р.ОТГОНЖАРГАЛ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

Аймгийн Засаг даргын Тамгын газрын I байр, Их суварга 505.
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081
Утас: Факс: 7036-2223, Цахим шуудан: azdtg@selenge.gov.mn
Цахим хуудас: www.selenge.gov.mn

2026.04.22 № 01/444

танай _____ -ны № _____

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус тайлангийн төсөлд холбоотой санал байхгүй болно.


М.Лхагвадорж
Н.ЛХАГВАДОРЖ

4326090568